

МАНАЙ “UB EVENT HALL”-Д БОЛОХ УУЛЗАЛТ 2-Р САРЫН 8 - 12-НЫ ӨДРҮҮД БОЛЖ ӨӨРЧЛӨГДЛӨӨ

Манай Бурханд харахан итгэж амжаагүй хүмүүст зориулсан уулзалт маань анх товлогдсон өдрүүд болох 2018 оны 2-р сарын 1-5 өдрүүдээс бага зэрэг хойшлон 2018 оны 2-р сарын 8-12 өдрүүдэд явагдахаар боллоо. Учир юу гэвээс энэхүү уулзалтын маань илтгэгч доктор Рон Клозе маань гэр бүлийн эрүүл мэндийн асуудлаар яаралтай АНУ-руу нутаг буцах шаардлагатай болсон билээ. Тиймээс бид хэдий Монголын үндэсний баяр цагаан сар ойртсон боловч энэхүү уулзалтаа цаг хугацааг нь багахан өөрчлөөд, хийхээр болсон юм. Бурхан бидний энэхүү үйлчлэлийг бүрэн дүүрнээр ивээнэ гэж найдаж байна. Энэхүү хэдэн өдрийн цуврал уулзалтууд маань бидний эргэн тойронд байгаа үл итгэгч найз нөхөд, гэр бүлийнхэн, хамтран ажиллагсадаа урих гайхалтай сайхан боломж болоод зогсохгүй энэ оны 3-р сард төлөвлөж буй томоохон сургалтын маань бэлтгэл туршилт болж өгөх юм. Энэ уулзалтууд бидэнд Бурханы хүмүүст зориулан юу хийдгийг тодорхойгоор харуулах нь дамжиггүй. Бид эхний өдрийн уулзалтаараа Чингис Хаан болон түүний Бурханы талаарх ойлголт харин хоёр дахь өдрийн уулзалтаараа зовлон бэрхшээл ба Монголчуудын хэлдгээр муу ёрын зүйл буюу чөтгөрийн талаар ярилцах болно. Түүнээс хойших өдрүүдийн уулзалтаар үл итгэгч хүмүүст зориулан библид гарч буй Бурханы талаарх ойлголтуудын талаар ярилцах болно. Итгэгч бус найзууд маань ч гэлтгүй манай сүмийн зарим гишүүд маань ч гэсэн энэ талаар өмнө нь сонсож байгаагүй гэдэгт эргэлзэхгүй байна. Тиймээс та бүхэн энэхүү гайхалтай боломжийг, мэдлэгийн их уурхайг, Ариун Сүнсний ховор цагийг мөчийг битгий алдаарай. Боломжтой бүхнийг уригтун! Нөгөө талаар энэ бол маш их залбирлыг өргөх цаг хугацаа юм. Ариун Сүнсний ажил явагдаж байх энэ үед бидний дайсан гараа хумхиж суухгүй нь тодорхой. “Тиймээс бид бусдын адил унталгүй, харин сэргэг бөгөөд эрүүл ухаантай байцгаая... Яагаад гэвэл Бурхан биднийг уур хилэнгийн төлөө бус, харин бидний Эзэн Есүс Христээр дамжуулан авралыг олж авахын төлөө томилсон юм.” (1-р Тесалоник 5:6,9) ■



2018 ОНЫ 2-Р САРЫН 7-НЫ ӨДӨР ЯВАГДАХ ТУСЛАГЧДЫН СУРГАЛТ

Нэгэнт бид энэхүү 2 болон 3-р сард болж буй сургалтанд магадгүй урьд өмнө нь сүмд ирж байгаагүй цоо шинэ хүмүүсийг олноор урьж байгаа учраас юу хийх ёстойгоо сайтар мэдэж байх шаардлагатай билээ. Тиймээс ирэх сарын буюу 2-р сарын 7-ны өдөр энэхүү баярт мэдээний уулзалтын зохион байгуулах багт орон ажиллаж буй туслахуудад зориулсан чухал сургалт “UB EVENT HALL”-д болох болно. Та бүхэн энэ талаарх тодорхой мэдээллийг өөрсдийн сүм цуглааны пасторуудаас дэлгэрэнгүй авахыг хүсэж байна. Хэрэв ямарваа нэгэн урьдчилан тооцоолоогүй шалтгааны улмаас энэхүү уулзалт “UB EVENT HALL”-ын зааланд болох боломжгүй байдал үүсвэл “Улаанбаатар Төв Сүм”-ийн төв танхимд явагдах болно. Та бүхэн өөрсдийн ахлагчдаас энэ талаар тодорхой мэдээллийг урьдчилан авахыг дахин хүсье.

Доорхи хүснэгтэд сүмүүдээс тус бүр хичнээн хүн энэхүү туслахуудын багт орсныг харуулсан байна:

Сүм	Эгнээний туслах	Бүртгэлийн баг	Утгагчид	Хангамж	Туслагчид	Цайны завсарлага
УБТСүм	10	2	4	2	4	2
Бусад	Сүм бүрээс 2	Сүм бүрээс 2	Сүм бүрээс 2		Сүм бүрээс 2	Сүм бүрээс 1

Үүнээс өөр үйлчлэлүүд мөн бий бөгөөд та бүхнийг урьж байна. Та бүхэн ямар үйлчлэлд туслахаа төлөвлөөд энэхүү сургалтанд хамрагдана уу.

40 ӨДРИЙН ЗАЛБИРЛЫН УРИАЛГА

Манай зарим сүмүүд 40 өдрийн залбирлын аянаа 1-р сарын 20-ны Шаббат өдрөөс эхлүүлсэн байна. Энэхүү залбирлын аяныг цаашид илүү үр дүнтэйгээр өнгөрүүлэх бас нэгэн санаа гарч ирж байна. Учир юу гэвээс энэхүү 40 өдрийн залбирлын(мацаг барилт, залбирал) гол утга санаа бол сүмийн гишүүд өдөр болгон залбирах явдал юм. Удаах чухал санаж байх ёстой зүйл бол энэхүү залбирлаар дамжуулан яг тухайлсан хэн нэгэний төлөө залбирах нь маш чухал билээ. Тиймээс энэхүү зааварчилгаа, зөвлөгөөг илгээж байна. Маш удахгүй та бүхний гар дээр, төрөлх хэлээр тань хүрэх болно гэдэгт итгэлтэй байна. Энэхүү зөвлөгөөнүүдийг харцгаая.

УРИАЛГА 1 – ГЭРТЭЭ АЛЬ ЭСВЭЛ СҮМ ДЭЭРЭЭ ЦУГЛАЖ УУЛЗАХ ТУХАЙ

Шаббатын өглөө та бүхэн бүгдээрээ хамт уулзахдаа энэхүү зохион байгуулалтыг хийнэ гэдэгт итгэлтэй байна. Сүмийн тань гишүүдийн хэн нь сүм дэрээ, хэн нь гэртээ цуглах эсхийг шийдэж зохион байгуулаарай. Мөн сүм дээр залбирахаар ирж буй хүмүүсийн тоог аль болох их байлгавал сайн юм. Дор хаяж гурван өөр гэр бүлийн төлөөлөл энэхүү сүм дээр болж буй залбиралд нэгдэж байвал сайн. Мөн өдөр бүр сүм дээр цуглах цагаа нарийвчлан тогтоорой. Энэхүү залбирлын группийн ахлагч болоод туслахыг сонгох хэрэгтэй. Мэдээж зарим гишүүд маань тэр

бүр энэхүү залбирлын цуглаануудад хамрагдаж чадахгүй байж болох ч санаа зовох хэрэггүй. Ямартай ч хоёр болон түүнээс дээш хүн Эзэний нэрээр цуглахад Эзэн тэдэнтэй хамт байдаг шүү дээ.(Матай 18:20) Та бүхэн залбирахаар цуглахдаа библийн амлалтуудаас уншсаны дараагаар залбирлаа эхэлж болно. Тийнхүү залбирахдаа та бүхэн сүмд ирдэггүй боловч урихыг хүсэж буй тодорхой хүмүүсийнхээ төлөө залбираарай. Мөн өдөр бүр цугларч чадвал маш их чухал юм. Бид бүхнийг Бурхан ивээх болно.

УРИАЛГА 2 – ДЕННИС СМИТТИЙН МАТЕРИАЛААС АШИГЛАХ ТУХАЙ

Боломжтой бол Amazon.com хуудсан дээр буй “Dennis Smith-ийн 40 өдрийн залбирлын” номнуудыг үзээрэй. Тэрээр яг энэхүү 40 өдрийн залбирлын талаар нийт 8 ном бичсэн бөгөөд ихэвчлэн дахин ирэлт, сүнслэг өсөлт, загалмай, эцсийн өдрүүдийн тухай сэдэвтэй юм. Хэрэвзээ энэхүү номууд монгол хэл дээр орчуулагдаагүй байсан ч хэн нэгэн англи хэлтэй сүмийн гишүүнийхээ тусламжтайгаар эдгээр номнуудаас өдөр бүр цуглаан дээрээ уншихыг хичээгээрэй.

УРИАЛГА 3 – “CONFERENCE CALL” АШИГЛАХ ТУХАЙ

Магадгүй сүм дээр болж буй залбирлын цуглаанд оролцох нь хүн бүрийн хувьд хүндрэлтэй байж болно.

Ялангуяа сүмээсээ хол амьдардаг болон ажлын цаг зэрэг шалтгаанаас үүдээд энэ мэт асуудлууд гарч болно. Энэ тохиолдолд 40 хоногийн залбирлын өдрүүдийн туршип залгаж болох нэг дугаарыг гаргаад(пастор болон түүний туслахууд хариуцана) хамтдаа орон зайнаас үл хамааран залбирч болно. Мөн Шаббатын цуглаанаараа тэрхүү дугаарлуу хэн хэзээ, хэдэн цагт залгах зэргээ хувиарлаж болох юм. Тийнхүү гишүүд өдөр бүр тэрхүү дугаарлуу залгаж хамтдаа залбирах нөхцөл боломж үүсэж байна.

УРИАЛГА 4 – “ДАГАЛДАГЧДЫН ҮЙЛС” НОМЫГ УНШИХ ТУХАЙ

Библийн шинэ гэрээний “Дагалдагчдын Үйлс(Үйл явдал ч гэж нэрлэдэг шинэ гэрээний тав дахь ном болох үйлс номын жинхэнэ нэр)” ном нь нийт хорин найман бүлэгтэй байдаг. Тиймээс энэхүү номын эхний хорин бүлгийг 40 хоногийн залбирлын өдрүүдийн эхний хорин өдөрт нь уншаарай. Залбирлын сүүлчийн 20 өдөрт ч мөн ялгаагүй эдгээр хорин бүлгээ дахин давтаж нэг уншаарай. Ийнхүү тухайн өдрийн уншсан бүлэг бүр тухайн сүмийн залбирлын өдөрт өөрийн гайхалтай ивээлийг, үр нөлөөг үзүүлнэ гэж найдаж байна. Жишээ нь та бүхэн үйлс номын 12-р бүлгийг уншлаа гэхэд тухайн өдрөө тэрхүү бүлэгт гарсан үйл явдалтай төсөөтэй нөхцөл байдалд буй үл итгэгч хүмүүсийн талаар залбирч болох юм. ■

ЧУХАМ АЛЬ БУРХАН ЮМ БЭ?

Чингис хаан бол Монголчуудын эцэг билээ. Найман зууны тэртээ Чингис хаан Монголын олон овог аймгуудыг нэгтгэн зангидаж, нэгэн цул хүчийг босгож чадсан юм. Тэр бол маш гайхалтай цэргийн стратегич, удирдагч хүн байсан бөгөөд шашны эрх чөлөө, худалдааны чөлөөт байдал болон чанд хууль, ёс зүйн сэргэлт зэрэг олон сайн зүйлсүүдийг дэлхийн хүнд төрөлхтөнд “бэлэглэсэн” билээ. Чингис хааны талаарх Монголчуудын бодол зүйрлэл нь Бурхантай ч дүйхүйц хэмжээний агуу их хүндэтгэлийг агуулж байдаг. Гэхдээ тэр Бурхан байсан гэж үү? Тэрээр бөө мөргөлийн зан үйлийг үйлдэж, мөнх хөх тэнгэрт залбирдаг байжээ. Магадгүй Чингис хаан өөрт хамгийн ойр байсан зүйлдээ л мөргөж, биширч байсан гэж хэлж болох юм. Гэвч өнөөдрийн бидэнд өөрөөр хэлбэл найман зууны хойно амьдарч буй бидэнд түүнд байснаас ч илүү их зүйлс, мэдээлэл байна. Өнөөдөр бидэнд Бурхан гэж Хэн болох талаар, Түүний хийж буй үйлсүүд нь юу болох талаар хэлж буй гайхалтай Бурханы Үгс байна. Энэ бол 2018 оны гуравдугаар сард болох уулзалтуудын явцад бидний олж мэдэх Бурхан билээ. Та бүхэн өөрсдийн урьж болох бүхий л хүмүүсийнхээ төлөө сүмдээ цуглан залбирахыг чин сэтгэлээсээ хүсье. Тийнхүү тэдгээр хүмүүсийг уриарай. Тэдгээр хүмүүс тагталзлаа ч тэднийг дахин уриарай. Тасралтгүй залбирагтун. Та бүхэн нүдэндээ ч итгэхээргүй гайхах болно. Тэдгээр урьсан хүмүүстээ энэхүү уулзалтууд бол урьд өмнө тэдний оролцож байсан уулзалтуудаас өөр, хамаагүй гайхалтай байх болно гэдгийг хэлээрэй. Тэдэнд энэхүү уулзалтуудаар дамжуулан Чингис хаанаас ч агуу Нэгэнтэй уулзах болно гэдгийг заавал сануулаарай. Тэд жинхэнэ тэнгэрийн Бурхантай уулзах болно гэдгийг хэлээрэй. Та бүхнээс хичээнгүйлэн хүсэж байна. ■